

ЭКОЛОГИЙН ЦАГДААГИЙН АЛБАНЫ 2020 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020.09.30

Улаанбаатар хот

Экологийн цагдаагийн албанаас энэ оны гуравдугаар улиралд Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийн хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2020 онд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан.

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр

Тус алба байгуулагдсанаас хойших хугацаанд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаарх мэдээллийг Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны 01/610 дугаар албан бичгээр Монгол Улсын Ерөнхий сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдад, 01/511 дүгээр албан бичгээр Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад;

Тус албаны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтэс нь хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд Цагдаагийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-д “Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан эрхийг эдэлнэ” гэж заасны дагуу экологийн асуудал хариуцсан байцаагч нарт “Улсын байцаагчийн эрх” олгуулах тухай саналыг Цагдаагийн ерөнхий газрын даргаар уламжлуулсан энэ оны 01/606 дугаар албан бичгээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт тус тус хүргүүлсэн.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2020 онд хяналтад авч, хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалтын дагуу бодлогын 1, шийдвэрийн хэрэгжилтийг хангахтай холбоотой 3 нийт 4 баримт бичгийн биелэлт үр дүнг тооцож, холбогдох газарт хүргүүлсэн. Үүнд:

- Улсын онцгой комиссын энэ оны 01 дүгээр албан даалгаврын холбогдох заалтын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, биелэлтийг энэ оны 16-2/1917 дугаар албан бичгээр;

- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Алт-2 үндэсний хөтөлбөр”-ийн биелэлт үр дүнг энэ оны 16-3/1348 дугаар албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст;

- Албаны сургалтын төлөвлөгөөний энэ оны гуравдугаар улирлын биелэлт, тайлан, мэдээг 16-2/1893, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт, тайлан, мэдээг 16-2/1900 дугаар албан бичгээр тус тус Цагдаагийн ерөнхий газрын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэст тус тус хүргүүлсэн.

Дээд шатны байгууллагаас нийт 16 үүрэг, ажлын чиглэл, албан даалгавар, зөвлөмжийг хүлээн авч, биелэлт, үр дүнг тооцон, холбогдох газарт хүргүүлж, алба, хэлтсийн дарга нараас 5 удаагийн үүрэг, ажлын чиглэлийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хүргүүлсэн. Албаны даргын А, Б нийт 29 тушаалыг төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Албаны даргын зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж, 5 асуудал хэлэлцсэний 20.0 хувь нь удирдлага зохион байгуулалтын чиглэлээр, 80.0 хувь нь хүний нөөцийн чиглэлээр хэлэлцэж, тодорхой шийдвэрүүдийг гаргаж, үр дүнг тооцсон.

Тус албаны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлангийн хурал, сахилгын зөвлөгөөнийг энэ оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 11.00-13.00 цагийн хооронд Цагдаагийн ерөнхий газрын 3 дугаар байрны хурлын зааланд алба, аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан алба хаагч нарыг хамруулан цахимаар зохион байгуулж, дүнг 16/1188 дугаар албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын

Захиргааны удирдлагын газарт, 16/1194 дүгээр албан бичгээр Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлсэн.

“Цагдаагийн болон дотоодын цэргийн алба хаагчдын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчаас өгсөн ажлын чиглэлийн биелэлт үр дүнг тооцож энэ оны 16/1241 дүгээр албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газарт;

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/163 дугаар тушаалаар баталсан “Цагдаа, дотоодын цэргийн алба, хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр, төлөвлөгөө, шалгуур үзүүлэлт”-ийг хэрэгжүүлэх үүрэг бүхий дэд зөвлөлийг албаны даргын А/28 дугаар тушаалаар байгуулж, хөтөлбөрийн хэрэгжилт, явц байдал, зохион байгуулсан ажлын талаарх танилцуулгыг энэ оны 16-2/1954 дүгээр албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтэст;

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн энэ оны “Объектын хамгаалалтын хуваарь батлах тухай” А/220 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд зохион байгуулсан ажил, арга хэмжээний танилцуулгыг энэ оны 16/1902 дугаар албан бичгээр Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанд;

Албаны 15 хоног тутам хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний танилцуулгыг 6 удаа нэгтгэж Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанд;

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн нэгдсэн санд 2015-2019 онуудад бүртгэгдсэн Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлгийн 24.1-24.9 дүгээр зүйлд заасан “Хүрээлэн байгаа орчны эсрэг” гэмт хэргийн нөхцөл байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйл, бууруулах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын танилцуулга, мэдээллийг энэ оны 16/1892 дугаар албан бичгээр Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Дүн шинжилгээ, судалгааны хэлтэст тус тус хүргүүлсэн.

Албаны энэ оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлангаар 20 хуудастай сэтгүүлийн эх бэлтгэлийг хийж, “Удам соёл” ХХК-иар 100 ширхгийг хэвлүүлэн 16-1/1163 дугаар албан бичгээр;

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, алба хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэх үүрэг, ажлын чиглэлийг 16/1156 дугаар албан бичгээр аймаг дахь цагдаагийн газар, хэлтэст тус тус хүргүүлсэн.

Тулгар төрийн 2229, Их Монгол Улсын 814, Ардын хувьсгалын 99 жилийн ой, Үндэсний их баяр наадмын өдрүүдэд тус хэлтсээс 4 алба хаагч Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газрын хоёрдугаар хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт энэ оны 07 дугаар сарын 11, 12-ны өдрийн 16.00-22.00 цагийн хооронд нийтийн хэв журам сахиулах чиглэлээр эргүүлийн үүрэг гүйцэтгэж, зөрчил дутагдалгүй ажилласан.

Баяр наадмын өдрүүдийг тохиолдуулан Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчаас цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дарга, захирагч нарт цахим хурлын үеэр өгсөн үүргийн биелэлтийг нэгтгэн 16/1214 дүгээр албан бичгээр Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанд хүргүүлсэн.

Улсын онцгой комиссын шийдвэрээр Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Франкфурт хотоос татан авсан Монгол Улсын иргэдийг Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Цэлмүүн трейд” ХХК-ий “Дрийм-1” зочид буудалд энэ оны 09 дүгээр сарын 24-ний өдөр байрлуулж, тусгаарлан ажиглах үеийн гадна хамгаалалтыг зохион байгуулсан.

Хамгаалалтад үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, шуурхай удирдлага, зохион байгуулалтаар ханган, энэ оны 09 дүгээр сарын 23, 24-ны өдрүүдийн нөхцөл байдлын талаарх танилцуулгыг албаны болон Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дарга нарт танилцуулж, ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын дарга болон зөвлөлийн гишүүдийн Улаанбаатар цагдаагийн хүрээний анги, байгууллагад ажиллах удирдамж, хуваарийн дагуу Цагдаагийн ерөнхий газрын дарга, Тэргүүн дэд дарга нар энэ оны 08 дугаар сарын 20-ны өдөр тус албаны үйл ажиллагаатай танилцсан.

Дээрх удирдамж, хуваарийн дагуу тус албаны болон Захиргааны удирдлагын хэлтсийн дарга нар энэ оны 08 дугаар сарын 21-ний өдөр Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төв, Санхүү, аж ахуйн албаны Хангалт үйлчилгээний төв, Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн үйл ажиллагаа, нөхцөл байдалтай танилцаж, алба хаагчдын санал хүсэлтийг сонсон, дүнг Цагдаагийн ерөнхий газрын даргад илтгэх хуудсаар танилцуулсан.

Архив, бичиг хэргийн үйл ажиллагааны чиглэлээр: Дээд шатны байгууллага болон бусад алба, газар, хэлтэс, төрийн болон төрийн бус байгууллагаас бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр давхардсан тоогоор нийт 618, үүнээс хугацаатай 134, энгийн 484 албан бичгийг хүлээн авч, удирдлагын заалт бичүүлэн холбогдох албан тушаалтанд шилжүүлж, алба хаагчдаас төслөөр ирсэн 851 албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн стандарт, Монгол хэлний зөв бичгийн дүрмийн дагуу алдаагүй бичиж, хэвлэмэл хуудсанд буулгаж ажилласан.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Архивын ерөнхий газраас боловсруулж байгаа “Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт”-д тусгуулах саналыг энэ оны 16-3/1278 дугаар бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Төв архивд хүргүүлсэн.

Хүний нөөцийн чиглэлээр: Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/173 дугаар тушаалаар тус албаны бүтэц, орон тоог шинэчлэн баталж, Мөрдөн байцаах албаны Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн орон тоо, цалингийн санг тус албанд шилжүүлсэнтэй холбогдуулан шилжин ирсэн алба хаагчдын цалингийн шатлалыг шинэчлэн тогтоож, хүний нөөцийн цахим сангийн баяжилтыг бүрэн хийсэн.

Тус албанд шилжин ажиллах, шинээр болон дэвшин томилогдох хүсэлт гаргасан 12 алба хаагчийн материалыг судалж, холбогдох алба, нэгжээс зөвшөөрөл ирүүлсэн 8 алба хаагчийн материалыг Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлэн, томилуулсан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Шагнал, урамшил олгох /код-925/ журам”-д заасан болзол шаардлага хангасан 8 алба хаагчийг шагнуулах санал, материалыг холбогдох газарт хүргүүлснээр Цагдаагийн ерөнхий газрын “Хүндэт жуух”-аар 1, “Албаны төлөө-I,II,III” медалиар 6 алба хаагч тус тус шагнуулсан.

Урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтний албан тушаалд ажиллаж байсан 3 алба хаагчийг офицерын бүрэлдэхүүнд оруулж, цагдаагийн дэслэгч цол олгуулах санал, материалыг Цагдаагийн ерөнхий газрын хүний нөөцийн хэлтэст хүргүүлэн шийдвэрлүүлсэн.

Албаны даргын тушаалаар томилогдсон 1 алба хаагчаар цагдаагийн тангараг өргүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг энэ оны А/36 дугаар тушаалаар батлан, тангараг өргүүлэх ажиллагааг зохион байгуулж, мөн оны Б/41 дүгээр тушаалаар Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсийн зөвшөөрлийн дагуу 1 алба хаагчид хугацааны цагдаагийн ахлагч цол олгосон.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад заасны дагуу тус албаны офицер бүрэлдэхүүний төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийг 2020 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс тооцож олгох шийдвэр гарсантай холбогдуулан албаны даргын энэ оны Б/40 дүгээр тушаалаар алба хаагчдын цалингийн шатлал, зэрэглэлийг шинэчлэн тогтоож, хүний нөөцийн мэдээллийн санд мэдээллийг бүрэн оруулсан.

Шинээр томилогдсон алба хаагчдыг албаны бахархал, үнэт зүйлийн талаар мэдлэг олгох, ажлын арга барилд сургаж дадлагажуулах, цагдаагийн албаны онцлогт дасгаж

төлөвшүүлэх зорилгоор 8 алба хаагч, ажилтанд албаны даргын тушаалаар халамжлан хүмүүжүүлэгч нарыг томилж, төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Соён гэгээрүүлэх, албаны сургалтын чиглэлээр: Тус албанаас зохион байгуулах албаны сургалтын төлөвлөгөөний дагуу энэ оны 3 дугаар улиралд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран алба хаагчдын мэдвэл зохих хууль, тогтоомж, тэдгээрийг хөгжүүлэх, дадлагажуулах, бие бялдрын бэлтгэлжилтийг хангах сургалтыг нийт 14 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 993 алба хаагчийг хамруулсан.

Мөн соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу мэдээлэл сурталчилгааны, соёл, хүмүүжлийн, биеийн тамирын нийт 16 ажил арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 1136 алба хаагч, ажилтныг хамруулсан.

Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан зарим тэмцээн, уралдааныг түр хугацаагаар хойшлуулсан бөгөөд алба хаагч, ажилтнуудын бие бялдрыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын “Сүлд” биеийн тамир, спортын хороотой гэрээ байгуулан, алба хаагчдыг долоо хоног бүрийн Лхагва гарагт спорт зааланд биеийн тамир, спортоор хичээллүүлж байна.

Алба хаагчдын ажлын бүтээмж, албандаа хандах хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулж буй “Дурсамж үлдээх мөч” арга хэмжээний хүрээнд энэ оны 07-09 дүгээр сард төрсөн 15 алба хаагчид төрсөн өдрийн мэндчилгээ, дурсгалын зүйлийг гардуулсан.

Захиргааны удирдлагын хэлтсийн нэрэмжит 14 хоногийн арга хэмжээний хүрээнд алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, нэгдмэл, эвсэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор зохион байгуулсан “Пүүл биллиардын аварга шалгаруулах тэмцээн”-ийг зохион байгуулж, эхний 3 байранд шалгарсан алба хаагчдыг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.

Алба хаагчдын дунд албаараа бахархах, итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх, албаны үйл ажиллагааны онцлогийг иргэд, олон нийтэд сурталчлах зорилгоор “Миний ажлын нэг өдөр” сэдэвт фото зургийн уралдааныг тус албаны зохион байгуулалтын нэгжүүд болон аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан алба хаагчдын дунд зохион байгуулж, дүнг нэгтгэн шалгарсан алба хаагчдыг шагнаж урамшуулсан.

Үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр: Шинээр батлагдсан, нэмэлт, өөрчлөлт орсон хууль тогтоомж, эрх зүйн 15 актыг бүртгэн алба хаагчдад танилцуулж, дотоод сүлжээний “Сургалтын цахим сан”-д байршуулан, онлайн-аар ашиглах боломжийг бүрдүүлэн ажилласан.

Дээд шатны байгууллагаас санал авахаар ирүүлсэн 10 журам, төлөвлөгөө, хуулийн төслийг алба хаагчдаар хэлэлцүүлж, гарсан саналыг тусгуулахаар Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалт, Хуулийн хэлтэст хүргүүлсэн.

Алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйн чиглэлээр: Аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан алба хаагчдын сахилга, ёс зүйн зөрчил болон гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон, холбогдон шалгагдсан талаарх судалгааг сар бүр нэгтгэн, шалтгаан нөхцөлийг судалж, албаны даргад танилцуулсан.

Тус албаны сахилгын /дэлгэрэнгүй, хураангуй/ болон албаны шалгалт, гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон, холбогдсон алба хаагчийн мэдээ, иргэдээс цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн гомдол, мэдээллийн мэдээг сар бүр заасан хугацаанд Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэст;

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны “Төрийн албанд ёс зүй, сахилга, хариуцлагыг сайжруулах тухай” 02 дугаар зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, дүнг 16-1/1200 дугаар албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэст, энэ оны эхний хагас жилд дотоод хяналт шалгалтын чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний тайланг 16-1/1164 дүгээр албан бичгээр Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст тус тус хүргүүлсэн.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Дүрэмт хувцас өмсөж хэрэглэх /код 917/ журам”, “Алба хаагчдын гадаад үзэмж биеэ авч явах байдал /код 921/ журам”-ын

хэрэгжилтийг хангах, мөн тусгаарласан объектын хамгаалалтад ажиллах алба хаагчдад 2 төрлийн зааварчилга хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсээс зохион байгуулж буй “Өнгө нэмцгээе-2020” нөлөөллийн аяны хүрээнд Хэрэг бүртгэх албанаас зохион байгуулсан “Харилцаа хандлага”, Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас зохион байгуулж буй “Хариуцлагатай алба хаагч” арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр: Албанд томилогдсон 7 алба хаагч хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ шинэчлэн гаргаж, <https://meduuleg.iaac.mn/> цахим хуудсанд шивснийг хянан баталгаажуулж, баталгааны маягтыг хүлээн авч, бүртгэсэн.

Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын энэ оны 3/204 дүгээр албан бичгээр ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийн дагуу шинээр болон шилжин томилогдсон 22 алба хаагчаас авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх баталгаа гаргуулсан авсан.

Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх ажлын хүрээнд бүтээсэн “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг” сэдэвт видео шторкийг тус албаны “Экологийн цагдаагийн алба” фэйсбүүк хуудаст байрлуулж, алба хаагчдаар судлуулан, түгээж ажилласан.

Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хэрэгжилтийн талаар

Тус албанаас хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажил, арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллаа.

Нөхцөл байдлын мэдээ: Улсын хэмжээнд энэ оны эхний 09 сард хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 1343 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь урьд оны мөн үеэс бүртгэгдсэн гомдол 833 буюу 1.6 дахин өссөн байна.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг энэ оны эхний 09 сард нийт 526 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 188 хэрэг буюу 55.6 хувиар өссөн үзүүлэлттэй, улсын хэмжээнд бүртгэгдсэн 19465 хэргийн 2.7 хувийг эзэлж хэргийн илрүүлэлт 49.2 хувьтай байна.

Бүртгэгдсэн 526 хэргийн 483 буюу 91.8 хувь нь орон нутагт, 43 буюу 8.2 хувь нь нийслэлд бүртгэгдсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад орон нутагт бүртгэгдсэн хэрэг 180 буюу 59.4 хувиар, нийслэлд бүртгэгдсэн хэрэг 8 буюу 22.9 хувиар тус тус өссөн.

Гэмт хэргийн ангиллаар хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 322 байснаас 514 болж 192 хэргээр буюу 59,6 хувиар өсч, хүнд гэмт хэрэг 16 байснаас 12 болж 4 хэргээр буюу 25.0 хувиар буурсан байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг бүртгэгдсэн зүйлээр нь авч үзвэл, 216 буюу 41.1 хувийг хууль бусаар мод бэлтгэх, 203 буюу 38.6 хувийг хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, 68 буюу 12.9 хувийг хууль бусаар ан агнах, 19 буюу 3.6 хувийг байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх, 12 буюу 2.3 хувийг химийн хорт аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах, 4 буюу 0.8 хувийг ой хээрийн түймэр тавих, 4 буюу 0.8 хувийг байгаль орчныг бохирдуулах гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран ажиллах төлөвлөгөөний 4 дүгээр заалт, “Байгаль эн тэргүүнд” төслийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Хогоор бүү хорло” арга хэмжээг 1 сарын хугацаатай зохион байгуулж, дүнг танилцуулсан. Арга хэмжээний хүрээнд дараах ажил, арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Үүнд:

Цахим орчинд олон нийтийн давлагаа үүсгэх зорилгоор ахуйн хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглах уралдааныг зохион байгуулж, 172 иргэн, аж ахуй нэгжээс ирүүлсэн

234 бүтээл, шинэлэг санааг олон нийтэд сурталчилсан. Барилгын хог хаягдлыг бууруулах зорилгоор барилга угсралтын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн дунд “Барилгын хог хаягдлын менежментийг сайжруулах” уралдааныг мөн адил зохион байгуулж, 45 байгууллага материал ирүүлснээс эхний 3 байранд орсон газруудад талархал гардуулсан.

Аюултай хог хаягдлын талаар иргэд, олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор худалдаа үйлчилгээний төвүүдтэй хамтран мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулж, кали, кадми, лити, мөнгөн ус зэрэг 20-иод төрлийн химийн хортой бодис агуулдаг ахуйн хэрэглээний хуруу зайны хог хаягдал хүлээн авах 43 цэгийг шинээр байгуулсан.

Уул, уурхайн ашиглалтаас бий болдог хог хаягдлыг бууруулах, нөхөн сэргээлтийг нэмэгдүүлэх зорилгоор “Уул уурхайн үндэсний ассоциац”-тай хамтран нөхөн сэргээлт сайн хийж байгаа 12 байгууллагын үйл ажиллагаа, сайн туршлагыг ижил төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуй нэгжид сурталчилж, ажилласан. Мөн ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Петровис” ХХК-тай хамтран “Crown”, “Land cruiser”, “Prius”, “Mongolian rajero club” зэрэг автомашин сонирхогчдын клубуудын хооронд “Эко жолооч” уралдаан зохион байгуулж, идэвхтэй оролцсон жолооч нарыг шагнаж урамшуулсан.

Арга хэмжээний хүрээнд хог хаягдлын хор уршгийг иргэд, олон нийтэд таниулах, урьдчилан сэргийлэх арга зам болон эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор зорилтод мэдээ 283, нөлөөллийн видео шторк 10, дэмжих видео 33, бүтээлч постер 66, дэмжих постер 66, лайв 20, подкаст 7 бэлтгэн албаны цахим хуудсаар түгээсэн нь давхардсан тоогоор нийт 5.629.536 хүнд хүрч, нийтийн цахим сүлжээгээр зохион байгуулсан ажил, арга хэмжээг 20 телевиз, 11 сайт, 5 өдөр тутмын хэвлэлд давхардсан тоогоор 103, 6 фм радиогоор цагийн мэдээ 380, аудио шторк 1440 удаагийн давталттай иргэд, олон нийтэд хүрсэн.

“Байгаль эн тэргүүнд” төслийн хүрээнд хог хаягдлаас үүдэлтэй хөрс, усны бохирдлын эх үүсвэрийг бууруулах, экологийн тэнцвэрт байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх, иргэдийн буруу дадал хандлагыг өөрчлөх, зөв соёлыг төлөвшүүлэх, эерэг өөрчлөлт гаргах зорилгоор зохион байгуулсан “Хогоор бүү хорло” арга хэмжээ нь хог хаягдлын бодит байдлыг мэдээлж, хогоос үүдэлтэй байгаль экологид учирч буй хор аюулыг иргэд, олон нийтэд таниулсан, тэдгээрийн хог хаягдлын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлсэн, дадал хандлагад нөлөөлсөн, зөв үйлдэлд уриалж, сэдэлжүүлсэн нийтийн дэмжлэг авсан нийгмийн захиалгат ажил болсон нь цахим орчинд бичигдсэн сэтгэгдэл, иргэд, олон нийтийн үйлдэл хандлагаас харагдсан.

Улсын Их Хурлын энэ оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эрхэм зорилгод “Хөрст дэлхий, унаган байгалиа хайрлан хамгаална” гэж тодорхойлсон. Төрөөс экологийн талаар баримтлах бодлогод эко аялал, жуулчлалыг бодит утгаар төлөвшүүлэх, байгалийн үзэсгэлэнт газар, биологийн төрөл зүйлийг зохистой ашиглах, хамгаалах чиглэлээр мэдээлэл сурталчилгааны тэргүүний арга барил, зохион байгуулалтын арга хэмжээ авахаар төлөвлөсөн. Дээрх зорилт, ажлын чиглэлийн хүрээнд аялал жуулчлалаас үүдэн хүрээлэн байгаа орчинд үүсч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газар, “Жайка” олон улсын байгууллагатай хамтран энэ оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс 1 сарын хугацаатай зохион байгуулсан “Байгаль эн тэргүүнд” төслийн хүрээнд “Ирлээ Явлаа Цэвэр” мэдээлэл, сурталчилгааны аяны зохион байгуулсан.

Арга хэмжээний хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран орон нутагт амрагч, аялагч нарт хариуцлагатай аяллын дүрмийг сурталчлах ажлыг 12 удаа зохион байгуулж, тэдний дэмжлэгтэйгээр автомашины наалт, тараах материал тус бүр 60.0, хогийн уут, тор 120.0, халаасны тамхины хогийн сав 5.0 ширхгийг тус тус тарааж, зөөврийн 40 ширхэг хогийн савыг шалган нэвтрүүлэх товчоодод байршуулсан.

Амрагч, аялагч нарт экологийн боловсрол олгох, байгальд хог хаягдал хаяхгүй байх уриалга, зөвлөмжийг аялал жуулчлалын клуб, баазууд, автомашин, дугуйн холбоод, урлагийн хамтлагууд болон цахимд нөлөөлөгч “Позитив Монголиа”, “Эгэлгүй Монгол

Жаалууд”, “Дэлхийгээр аялагчдын групп” зэрэг иргэд, байгууллагуудад шинэлэг хэлбэрээр хүргэсэн.

Орон нутаг, Улаанбаатар хотын төв замын сурталчилгааны самбарт аяны уриалгыг байршуулж, үүрэн холбооны “Юнител”, “Скайтел”, “Мобиком корпорац”-ийн 6.0 сая хэрэглэгчид зорилтот мессежийг илгээж, богино долгионы 12 FM радиогоор цагийн мэдээгээр 760, аудио шторк хэлбэрээр 2880 удаагийн давталттайгаар түгээсэн.

Иргэд, олон нийтийг байгаль орчинд зохистой аялах, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тусгай хамгаалалттай бүс нутгийн дэглэм журмыг сахих, тэдний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор лайв 22, подкаст 5, влог 5, нийт 33 ярилцлага, нэвтрүүлгийг бэлтгэн хүргэсэн.

Горхи тэрэлжийн Байгалийн цогцолборт газар, Туул голын сав газрын хамгаалалтын захиргаа, Нийслэлийн онцгой байдлын аврах 105 дугаар ангийн завьт эргүүлтэй хамтран цагдаагийн байгууллагаас морьт эргүүл ажиллуулж, 20 удаагийн эргүүл хяналт шалгалтыг нийслэлийн ногоон бүсэд зохион байгуулан, хүрээлэн байгаа орчны эсрэг 1 гэмт хэрэг, 64 зөрчлийг илрүүлэн 6.4 сая төгрөгийн торгууль оногдуулсан. Мөн байгалийн үзэсгэлэнт газар, биологийн төрөл зүйлийг зохистой ашиглах, хамгаалах чиглэлээр хяналт, шалгалтыг 42 удаа зохион байгуулж, гэмт хэргийн шинжтэй 19, зөрчлийн шинжтэй 132 үйлдлийг илрүүлэн, 28600 аялагчид эрх зүйн туслалцаа, зөвлөгөө өгсөн.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, амрагч, аялагч нарт аялал жуулчлалын боловсрол олгох, байгаль хамгаалах ажилд иргэний оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 420 мэдээ, мэдээллийг нийтийн цахим сүлжээнд байршуулсан нь давхардсан тоогоор 11.7 сая хүнд хүрч, 152.9 мянган хүнд таалагдаж, 52.4 мянган хүн бусдад хуваалцаж, 54.8 мянган хүн эерэг сэтгэгдэл илэрхийлсэн байна.

“Байгаль Эн Тэргүүнд” төслийн хүрээнд байгаль орчныг хамгаалах тухай багц хуулийн хэрэгжилтийг хангах, байгалийн нөөц баялаг, биологийн олон янз байдлыг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах, эзэмшихтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, иргэдийн эрх зүйн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, байгаль орчны тэнцэл алдагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл сурталчилгааны “Цэнхэр алт усаа хайрлая”, “Ой модоо хайрлая” хэсэгчилсэн арга хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ойн бодлого зохицуулалтын газар, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газартай хамтран энэ оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс нэг сарын хугацаатай зохион байгуулан ажиллаж байна.

Арга хэмжээний хүрээнд энэ оны 09 дүгээр сарын 09-ний өдөр “Цэнхэр алт усаа хайрлая”, “Ой модоо хайрлая” арга хэмжээний хэвлэлийн бага хурлыг Цагдаагийн ерөнхий газрын 3 дугаар байранд зохион байгуулсан. Мөн Монголын үндэсний олон нийтийн телевиз, ТВ5, ТМ, ТВ6, VTV, MNC, UBS, Өлзий, Сүлд Parliament зэрэг 11 телевиз, gogo.mn, mnb.mn, zarig.mn, analiz.mn, urug.mn, parliament.mn зэрэг 12 сайт, өргөн болон богино долгионы 3 радиод 41 мэдээ, мэдээлэл, нийтийн цахим сүлжээнд 62 зурагт хуудас, 28 видеог байршуулсан нь 5.837.564 хүнд хүрсэн байна.

Тус арга хэмжээг дэмжиж цахим орчинд нөлөөлөгч олны танил 300 хүн ковер фрэймээ сольсны дунд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Шадар сайд Г.Занданшатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл нар албан ёсоор өөрийн цахим хуудаснаа “Цэнхэр алт усаа хайрлая”, “Ой модоо хайрлая” уриалга бүхий пост нийтэлж, тус арга хэмжээнд нэгдэж буйгаа илэрхийлсэн.

Зохион байгуулсан нөлөөллийн ажил, арга хэмжээг дурдвал:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, “Ойн тухай хууль”-ийн 31 дүгээр зүйлийн 3.1 дэх заалт, “Байгаль эн тэргүүнд” төслийн хүрээнд хэрэгжүүлж буй “Цэнхэр алт усаа хайрлая”, “Ой модоо хайрлая” мэдээлэл сурталчилгааны хэсэгчилсэн арга хэмжээг идэвхжүүлэх зорилгоор Байгаль орчин аялал жуулчлалын яамтай хамтран “Эх дэлхийдээ хүчилтөрөгч бэлэглэе” уриа дор энэ оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд “Ой модоо хайрлая” өдөрлөгийг зохион байгуулсан.

Өдөрлөгийн арга хэмжээнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Цагдаагийн ерөнхий газрын дарга, зөвлөлийн гишүүд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын суурин зохицуулагч Винод Ахужа, Тапан Мишра нар болон тус албаны алба хаагчид оролцон Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 100 мод тарьж, хуурай газрын экосистем, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулж ажилласан.

Ойн нөөцийн хомсдол, усны бохирдлын эх үүсвэр түүний учир шалтгааныг иргэд олон нийтэд таниулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, буруу дадал хандлагыг өөрчлөх, зөв соёлыг төлөвшүүлэх зорилгоор “Norphei Art Gallery”, “Улаанбаатар” аялагч клуб, “I berry brand”-тэй хамтран “Ус ба мод” харьцуулсан фото зургийн үзэсгэлэнг энэ оны 09 дүгээр сарын 17-20-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Тус албанаас хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийн зэрэгцээ эх дэлхий, байгаль орчноо хайрлан хамгаалах, цөлжилттэй тэмцэх үйлсэд нэгдэж Монголын үл хөдлөх хөрөнгийн удирдлагын академитай хамтран “Реалтор төгөл”-д, “Дэлхийн цэцэрлэг хүрээлэн Монголд” ТББ-тай хамтран Баянзүрх хайрхны ар хормойд бүйлс, шинэс модыг тарьсан.

Мэдээлэл судалгааны чиглэлээр: Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын танилцуулга, цагаан мэдээг сар бүр өссөн дүнгээр нэгтгэж, удирдлагуудад танилцуулан, мэдээ, мэдээллээр ханган ажилласан. Мөн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын экологийн асуудал хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгч, мөрдөгч, байцаагч нарын ажлын мэдээг ажил дүгнэх хүснэгтийн дагуу нэгтгэж, аймаг дахь цагдаагийн газар хэлтсүүдэд хүргүүлсэн.

Гэмт хэргийн шинжтэй 56, зөрчлийн шинжтэй 77, нийт 133 гомдол, мэдээллийг хүлээн авч бүртгэн, гомдол, мэдээллийн шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан. Дүүрэг дэх прокурорын газруудаас харьяаллын дагуу ирүүлсэн хэрэг бүртгэлтийн 19 хэрэг, гэмт хэргийн шинжтэй 3 гомдол, мэдээллийн хариуцсан ажилтныг өөрчилж, мөн хэлтэс хооронд шилжүүлсэн 8 хэргийн хөдөлгөөнийг хийсэн.

Аймаг дахь цагдаагийн газар, хэлтсүүдэд шалгагдаж байгаа хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн хохирогч, хохирлын маягтыг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 701/ “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээллийн сан бүрдүүлэх”-ын 701.6.3.а-д заасны дагуу “Даруй” буюу тухайн ажиллагааг эхэлмэгц, эсхүл дуусмагц гэмт хэргийн мэдээллийн санд биечлэн үнэн зөв, гүйцэд оруулахад анхаарч, хэрэгжилтийг ханган ажиллах талаар 16-3/1262 дугаар албан бичгээр;

Улсын хэмжээнд энэ оны эхний 08 сард бүртгэгдсэн хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл, танилцуулгыг энэ оны 16-2/1778 дугаар албан бичгээр Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Дүн шинжилгээ, судалгааны хэлтэст хүргүүлсэн.

Мөн 7 хоног бүрийн “Баасан” гарагт тухайн 7 хоногт бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн танилцуулга, алба хаагчдаас мэдээллийн санд алдаатай, дутуу оруулсан маягтууд болон мэдээллийн санд анхаарах зарим асуудлын талаар гарын авлага бэлтгэн, удирдлагуудад танилцуулан ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын нэгдсэн системийн гомдол мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийн санд шивэгдсэн төв, орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан алба хаагчдаас 216 маягтуудыг нэг бүрчлэн хянаж, 41 маягтыг шаардлага хангаагүй төлөвт буцаан, засварлуулан ажилласан. Мөн мэдээллийн сангаас холбогдох алба хаагч нарт 6 удаагийн судалгааг гарган өгч, холбогдох журмын дагуу бүртгэл хөтөлсөн.

“Эрүүгийн хариуцлага, хүлээлгэсэн хүн хуулийн этгээдийн мэдээллийн сан бүрдүүлэх, лавлагаа олгох /код 706/ журам”-ын дагуу 94 иргэний эрүүгийн хариуцлага хүлээсэн эсэхийг шалгаж, лавлагаа олгон, бүртгэл хөтөлсөн.

Мэдээлэл технологи, холбооны чиглэлээр: Алба хаагчдын албаны компьютерт шинээр үйлдлийн систем суулгасан 10, domain тохиргоо 19, outlook mail тохиргоо 30, линк тохиргоо 31, принтер тохиргоо 32, программ суулгасан 18, сүлжээний холболт, гэмтэл засварласан 12 нийт 177 удаагийн гэмтэл засвар, тохиргоог хийн хэвийн ажиллагаанд

оруулсан. Алба хаагчдын домайн нууц үг сэргээх болон шинээр хаяг үүсгүүлэх 15 удаагийн хүсэлтийг Мэдээллийн технологи, холбооны төвд хүргүүлж шийдвэрлүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2.2.7 дахь “Цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээнд сумдын хэсгийн төлөөлөгчийн ажлын байрыг “DirectAccess” системээр шинэчлэн холбох.” заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор аймаг дахь цагдаагийн газруудын экологийн асуудал хариуцсан байцаагч нарын албан хэрэгцээний компьютерын судалгааг авч, нэгтгэн албаны даргад танилцуулсан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн техник хэрэгслийг эзэмших, хадгалах, бүртгэх хөтлөх /код 715/ журам”-ын төслийг алба хаагчдаар хэлэлцүүлэн гарсан саналыг 16-1/1201 дүгээр албан бичгээр Мэдээлэл, дүн шинжилгээ шуурхай удирдлагын албаны Мэдээллийн технологи, холбооны төвд хүргүүлсэн.

Тус албаны хэт богино долгионы радио холбоонд ашиглах радио торны нэр, дуудлагын тушаалыг албаны даргын энэ оны А/31 дүгээр тушаалаар шинэчилэн батлуулсан.

Гурав. Санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний талаар

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх хэсэгт заасны дагуу тус албаны 2021 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төсөөллөө энэ оны бодит гүйцэтгэлд тулгуурлан, дараа онд шаардлагатай хөрөнгө, материалын төсвийг тооцоолж, холбогдох эрх зүйн актын дагуу боловсруулан 16/1147 дугаар албан бичгээр Санхүү, аж ахуйн албанд хүргүүлсэн.

Тус албаны алба хаагчдын 07-09 дүгээр сарын цалин болон ээлжийн амралтын мөнгийг бодож олгон, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст 07-09 дүгээр сарын шимтгэлийн тайлан, Татварын хэлтэст 02 дугаар улирлын цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдуулан суутгасан албан татварын тайланг тус тус илгээсэн.

Тус албаны эд хөрөнгийн 2020 оны эхний хагас жилийн тооллого явуулах ажлын хэсгийг албаны даргын А/24 дүгээр тушаалаар баталгаажуулж, хагас жилийн тооллогоор үндсэн хөрөнгийн 3 данс, бараа материалын 5 данс, эд хариуцагч нарт шилжүүлсэн карттай хөрөнгө нэг бүрийг тоолж, дүнг “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-д танилцуулсан.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх тогтоол шийдвэрийн дагуу данс бүртгэлд тусгасан хөрөнгийн тайланг Санхүү, аж ахуйн албанд;

Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн алба хаагчидтай шийтгэлийн хуудасны тооцоо нийлж, үнэт цаасны тооцооны тайланг Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Санхүү, аж ахуйн хэлтэст тус тус хүргүүлсэн.

Мөн тусгаарлан ажиглах үеийн гадна хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад халдвар хамгааллын нэг удаагийн хувцас, хэрэглэл шийдвэрлүүлэх хүсэлтийг 16/1877 дугаар албан бичгээр Санхүү, аж ахуйн албанд хүргүүлж, шийдвэрлүүлсэн.

Алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр: Монгол Улсын Засгийн газрын энэ оны 60 дугаар тогтоолоор “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Сүхбаатар дүүрэгт байрлах барилгыг тус албаны мэдэлд балансаас балансад шилжүүлсэнтэй холбогдуулан уг барилгын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах Ажлын хэсгийг Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/204 дүгээр тушаалаар байгуулсан.

Дээрх Ажлын хэсгийн хурлын шийдвэрээр “Рэд лайн” ХХК-аар хийж гүйцэтгэхээр ирүүлсэн саналыг шалгаруулан Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулж, барилгын засварын ажил гүйцэтгэх гэрээ /ЦЕГ-2020/362/-г энэ оны 09 дүгээр сарын 01-ний өдөр байгуулан барилга буулгалт, нураалтын ажлыг бүрэн хийж дуусгасан.

Мөн гэрээний дагуу 40.0 хувийн санхүүжилтийг гүйцэтгэгч компанид шилжүүлж, вакуум цонхнуудыг суулган, суурийн даацын арматурын бэхэлгээг хийн, бетон цутгалт хийхэд бэлэн болгож, 380 Вт самбарын угсралтыг хийж цахилгааныг залгуулан, дулааны узелийн байрыг барьж, шугамд холбох бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 38 дугаар тогтоолын 6 дахь хэсэгт заасны дагуу уг барилгын газар эзэмших эрхийг тус албанд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэж өгөх хүсэлтийг энэ оны 16/1849 дүгээр албан бичгээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Барилга, архитектурын сургуулийн Оношилгоо, зураг төсөл, судалгааны “Реконстакшн” төвийн “Техникийн дүгнэлт”-ийг гаргуулан, барилгын ажлын эскиз зургийг батлуулахаар 16/1831 дүгээр албан бичгээр Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газарт;

Барилгын цэвэр, бохир усны гэрээг тус албатай шинэчлэн байгуулах хүсэлтийг 16-2/1661 дүгээр албан бичгээр Ус сувгийн удирдах газарт, эрчим хүчээр хангах гэрээг шинэчлэн байгуулах хүсэлтийг 16-2/1662 дугаар албан бичгээр “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Сүхбаатар дүүргийн хэрэглэгчдэд үйлчлэх төвд, 2020-2021 оны дулаанаар хангаж, гэрээг шинэчлэх хүсэлтийг 16/1668 дугаар албан бичгээр “Улаанбаатар дулаан сүлжээ” ТӨХК-д тус тус хүргүүлсэн.

Аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан алба хаагчдын орон сууцны нөхцөл, гэр бүлийн байдал, түүний ажил эрхлэлт, албаны тээврийн хэрэгслийн талаарх судалгааг авч, нэгтгэн нутаг дэвсгэрийн төр захиргааны байгууллагатай хамтран албан тушаалын байр олгох, томилогдсон алба хаагч, түүний гэр бүлийн гишүүдэд дэмжлэг үзүүлэхэд шаардагдах зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусгуулан шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах тухай 16/1303 дугаар ажлын чиглэлийг аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн дарга нарт;

Аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн 46 сумдын экологийн асуудал хариуцсан байцаагч нарын албан хэрэгцээнд шаардлагатай байгаа компьютер, түүний дагалдах хэрэгслийг шийдвэрлүүлэх хүсэлтийг 16/1223 дугаар албан бичгээр тус тус Санхүү, аж ахуйн албанд хүргүүлсэн.

Арав. Цаашид хийх ажлын талаар

- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 60 дугаар тогтоолоор “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Сүхбаатар дүүрэгт байрлах барилгыг тус албанд балансаас балансад шилжүүлсэнтэй холбогдуулан уг барилгын засварын ажлыг “Рэд лайн” ХХК-аар гүйцэтгүүлж, хүлээн авах;

- Албаны 2020 онд хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээлэх, хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх баримт бичгийн жагсаалтын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох;

- Тус албаны энэ оны 03 дугаар улирлын үйл ажиллагааны тайлангийн хурал, сахилгын зөвлөгөөнийг зохион байгуулах;

- Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас зохион байгуулж буй “Хариуцлагатай алба хаагч” арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулах;

- Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/163 дугаар тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн алба, хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах;

- Алба хаагчдын ажлын бүтээмжийг дээшлүүлж, идэвхийг өрнүүлэх, хамт олны дунд нэгдмэл, эвсэг уур амьсгалыг бүрдүүлэх чиглэлээр соён гэгээрүүлэх ажлын хүрээнд тэмцээн уралдаан зохион байгуулах;

- “Ус үндэсний хөтөлбөр”-ийн 2.1 дэх заалт, “Байгаль эн тэргүүнд” төслийн хүрээнд хэрэгжүүлж буй “Цэнхэр алт усаа хайрлая” мэдээлэл сурталчилгааны арга хэмжээг

эрчимжүүлэх зорилгоор “Эх дэлхийн цэнгэг усаа гамная” уриа дор олон нийтэд мэдээлэл хүргэх өдөрлөг арга хэмжээг зохион байгуулах;

- “Байгаль Эн Тэргүүнд” төслийн хүрээнд зохион байгуулж буй “Ой модоо хайрлая”, “Цэнхэр алт-Усаа хайрлая” арга хэмжээний дүнг нэгтгэж, танилцуулах;

- Байгаль орчин, аялал жуулчлал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран улсын хэмжээнд зохион байгуулж буй “Нөхөн сэргээлт-2020” ерөнхий арга хэмжээний дүнг нэгтгэж танилцуулах;

- “Бодис-2020” нэгдсэн арга хэмжээг эрчимжүүлж, үр дүнтэй зохион байгуулах;

- Ойн дагалдах баялаг болох хуш модны самар хориглосон хугацаанд бэлтгэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулах.

ЭКОЛОГИЙН ЦАГДААГИЙН АЛБА